



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2016 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 133

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газрын түрээсийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнгээр илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах зорилгоор ТОГТООХ нь:

1. “Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газрын 2013-2015 он, 2016 оны 3 дугаар улирлын түрээсийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын тайланг хавсралтаар баталсугай.

2. “Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газар (С.Энхбаяр)-т дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

а/ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төрийн сангийн дансанд түрээсийн орлогыг зохих журам, эрх зүйн актын дагуу тооцож 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн төвлөрүүлэх;

б/ “Реньюмаг” ХХК, “Тэс петролиум” ХХК, “Монгол хьюндай автотомив” ХХК, “Бат үрс” ХХК болон холбогдох журмыг зөрчиж зөвшөөрөлгүй байгуулсан бусад үл хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээг цуцалж, түрээсийн гэрээг шинэчлэн байгуулах;


в/ Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө гарган, биелэлтийг 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Авто гараашийн зориулалттай түрээсийн орлого нь улирлын чанартай, тогтмол бус байдгийг харгалзан улсын төсөвт төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийг дотоод үйл ажиллагаандаа зарцуулахыг “Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газар (С.Энхбаяр)-т зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НЯМ-ОСОР

З.Талаа Б.ГАВАА